



МОНГОЛ УЛСЫН  
ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 24-р сарын 26<sup>т</sup> өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

Гадаадад сургах, сургалтын  
төлбөр олгох тухай

Өндөр хөгжилтэй оронд магистрант суралцуулах ажлыг зохицуулах,  
зохион байгуулах комиссын 1999 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн  
хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. 1998 онд сонгон шалгаруулалтад орж тэнцсэн Д.Нансалмааг  
ЭМНХЯ-ны захиалгаар анагаах ухааны мэргэжлээр Австрали улсын Өмнөд  
Уэльсийн их сургуулийн магистрантурт, Ядамсүрэнгийн Халиунг АНУ-ын  
Өмнөд Индианы их сургуулийн магистрантурт БХЯ-ны захиалгаар  
бизнесийн удирдлагын мэргэжлээр 1999 оноос эхлэн 2 жилийн  
хугацаагаар суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дүгээр  
хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын  
магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг  
санхүүжүүлэх журам"-ын дагуу ОХУ-ын Владивостокийн их сургуулийн  
электроникийн тэнхмийн аспирант Г.Сэвжидсүрэн, Барнаулын хөдөө аж  
академийн докторант Ж.Мижиддорж, ОХУ-ын урлагийн академийн  
аспирант Х.Жамбалжамц, Москвагийн ОУХДС-ийн магистрант Э.Булган  
нарт сургалтын болон эрдмийн зэрэг хамгаалах зардал, Чех улсын Прагийн  
консерваторийн оюутан Г.Түмэнжаргалыг СТС-ийн зээлээр суралцуулах,  
Япон улсын Обирины их сургуулийн магистрант Д.Нямаа, БНСУ-ын Сүн  
Чонхяны их сургуулийн магистрант Б.Чимэдмаа, АНУ-ын Хойд  
Кароланагийн улсын их сургуулийн докторант А.Ундраа, АНУ-ын Чикаго  
хотын киноны дээд сургуулийн оюутан Н.Лянхуа, АНУ-ын Ютай Валлу  
улсын коллежийн магистрант Д.Гансух нартай гэрээ байгуулан нэг жилийн  
сургалтын зардал, Энэтхэгийн Калькуттын их сургуулийн аспирант  
Д.Алтанзаяагийн ШУБЯ-тай 1995 онд байгуулсан гэрээг 2000 оны 12  
дугаар сарын 31 хүртэл сунгаж, түүнд сургуульдаа ирж, очихын зардлыг тус  
тус олгох, Я.Халиун, Д.Нансалмаа нартай гэрээ байгуулан холбогдох  
төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү  
тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг  
зохицуулах газар /С.Алтангэрэл/-д тус тус даалгасугай.

ГЭГЭЭРЛИЙН САЙД

А.БАТТӨР